



**ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН
2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

ГОВЬ-АЛТАЙ АЙМАГ ДАХЬ УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН 2021 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Д/д	Стратегитөлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төс өв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин	Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэлийн хувь
НЭГДҮГЭЭР ЗОРИЛГО:БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
Зорилт 1. Улсын бүртгэлийн үйл ажиллагааг цахимжуулж, техник, тоног төхөөрөмж, программ хангамжийг сайжруулна./Алсын хараа-2050 зорилт 5.3 дахь заалт,Говь-Алтай аймгийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн 5.1 дэхь заалт,Говь-Алтай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.4 дэхь заалт, УБЕГ-ын 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө/							
1.1.1	Нэгдсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбох	-	Онлайн сүлжээнд холбосон сумдын тоо;	Тус аймгийн 10сум, 1 тосгон улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбогдсон.	Нэгдсэн сүлжээнд холбогдоогүй сумдыг улсын бүртгэлийн онлайн сүлжээнд холбоно.	Тус аймгийн нийт 18 сум 2 тосгоныг энэ оны 06 сард багтаан 100 хувь иргэний бүртгэлийн онлайн сүлжээнд бүрэн холбосон болно.	100%
1.1.2	Улсын бүртгэлийн цахим мэдээллийн нэгдсэн сан, мэдээллийн нэгдсэн сүлжээ, мэдээллийн системийн хэвийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хариуцах, техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах	-	Тоног төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагаанаас шалтгаалсан доголдлыг арилгасан тоо;	2021 онд хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 70 удаа засвар үйлчилгээг хийсэн.	Улсын бүртгэлийн нэгдсэн мэдээллийн сан, техник, тоног төхөөрөмжийн хэвийн ажиллагаа хангагдсан байна.	Тайлант жилийн байдлаар хэлтсийн хэмжээнд ашиглагдаж буй техник, тоног төхөөрөмжид давхардсан тоогоор нийт 98 удаагийн засвар үйлчилгээг хийсэн байна. Хуучин тоног төхөөрөмжийг актлах жагсаалтыг гаргаж ерөнхий газарт хүргүүлсэн. Энэ оны 08 дугаар сарын 22-ны өдөр БНСУ-ын Солонгосын олон улсын хамтын ажиллагааны байгууллага буюу КОЙКА-гийн буцалтгүй тусламжаар хэрэгжүүлж буй “Улсын бүртгэлийн системийн үйл ажиллагааг дэмжих төсөл”-ийн хүрээнд тус хэлтсийн нийт 18 сум 2 тосгоны улсын бүртгэгч нарт core i5 үзүүлэлттэй DELL OPTIPLEX 3080 маркийн суурин компьютер, HP LAZERJET MFP 428-429 маркийн 3 үйлдэлт принтер, CROSSMATCH EF200 хурууны хээ уншигч, CANON POWER SHOT SX70HS загварын зургийн аппарат, камерийн суурь хөл зэрэг тоног төхөөрөмжийг дагалдах хэрэгсэлийн хамт, мөн 11 сумд тог тогтворжуулагч хүлээлгэн өглөө.	100%
1.1.3	Хэлтсийн үйлчилгээний	-	Цахим үйлчилгээний булангаар	Цахим үйлчилгээ болох E-баримтаар төлбөр	Цахим буланг үйл ажиллагаанд хэрэглэж эхэлсэн	Иргэдэд төрийн үйлчилгээг хөнгөн шуурхай үзүүлэх зорилгоор Улсын бүртгэлийн ерөнхий газраас нэвтрүүлж байгаа бүхий л цахим	100%

	танхимд цахим үйлчилгээний булан бий болгох		үйлчлүүлсэн үйлчилгээний тоо;	төлсөн 34 иргэний мэдээллийг сүлжээнд баталгаажуулж ажилласан. Мөн e-mongolia цахим системээр үйлчилгээ авах талаар давхардсан тоогоор 245 иргэнд мэдээлэл өгч, хэлтсийн фэйсбүүк хаяг, цахим хаягаар дамжуулан сурталчилгаа, мэдээлэл өгч ажилласан.	байна.	үйлчилгээнүүдийг өөрийн цахим хуудас, фэйсбүүк хаягуудаар иргэдэд сурталчилан ажиллаж байгаа бөгөөд иргэд өөрөө өөртөө үйлчлэх “Цахим үйлчилгээний өрөө”-г тохижуулж компьютер, тоног төхөөрөмж суурилуулан ажиллаж байна. Мөн иргэд цахим үйлчилгээнүүд болох цахимаар лавлагаа авах, хуулийн этгээдийн нэр баталгаажуулах, болон бусад мэдээллийг хэлтсийн мэдээлэл технологийн ажилтан нэг бүрчлэн зааварчилгаа өгч иргэдтэй хамтран ажиллаж байгаагийн зэрэгцээ “Цахим өрөө” болон E-mongolia цахим үйлчилгээний системээр давхардсан тоогоор 562 иргэн үйлчилгээ авсан байна.	
1.1.4	Үйлчилгээний төлбөр, хураамжийг цахим машин, төлбөрийн системээр авах нөхцлийг бүрдүүлж, сурталчлан ажиллах	-	-Цахим машин, төлбөрийн системээр хийгдсэн төлбөр хураамжийн тоо; -Сурталчилсан байдал;	2020 онд E-баримтаар төлбөр төлсөн 34 иргэний мэдээллийг сүлжээнд баталгаажуулж ажилласан. Мөн Киоск цахимтөлбөрийн машинаар нийт 273 иргэн бүртгэлийн үйлчилгээний хураамж төлсөн байна.	Цахим хэлбэрээр төлбөр төлсөн иргэдийн тоо нэмэгдсэн байна.	2021 оны 12 сарын 01-ны байдлаар E-баримтаар төлбөр төлсөн 175 иргэний мэдээллийг сүлжээнд баталгаажуулж ажилласан. Мөн Киоск цахим төлбөрийн машинаар нийт үйлчилгээ авч буй иргэдийн 90% нь бүртгэлийн үйлчилгээний хураамж төлсөн байна.	100%
...	...						
ХОЁРДУГААР ЗОРИЛГО: ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ							
Зорилт 2. Улсын бүртгэлийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлж, иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг түргэн шуурхай, чанартай үзүүлнэ.							
2.2.1	Улсын бүртгэлийг хууль тогтоомж, холбогдох журмын дагуу хөтлөх	-	-Бүртгэлийн тоо;	Өмнөх онд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 6776, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 386, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн	Улсын бүртгэл үнэн зөв хөтлөгдөж, иргэдэд хүртээмжтэй хүрсэн байна.	Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 7678, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр 234, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 4420 бүртгэлийг тус тус хийж иргэн, хуулийн этгээдэд үйлчилгээ үзүүлсэн байна.	100%

				чиглэлээр 3564 бүртгэл тус тус хийгдсэн.			
2.2.2	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдүүдийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэлжүүлж, гэрчилгээ олгох	-	-Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн салбар төлөөлөгчийн газрыг бүртгэсэн тоо; -Олгосон гэрчилгээний тоо;	2020 оны жилийн эцэст гадны аймаг нийслэлийн харьяа 8 салбар төлөөлөгчийн газар бүртгэж гэрчилгээ олгосон.	Аймгийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээдийн бүртгэлтэй салбар төлөөлөгчийн газрыг урьд оны мөн үеэс 1%-иар нэмэгдүүлнэ.	Тайлант хугацаанд бүртгүүлэх хүсэлт гаргасан гадны аймаг, нийслэлийн харьяа 3 салбар төлөөлөгчийн газрыг бүртгэж гэрчилгээ олгосон.	100%
2.2.3	Улсын бүртгэлийн байгууллагаас мэдээлэл, лавлагаа өгөх	-	-Улсын бүртгэлтэй холбоотой олгосон мэдээлэл, лавлагаа, нотлох баримтын тоо; -Эрхийн улсын түтгэлзүүлсэн бүртгэлийн тоо;	2020 онд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 3426, хууль хяналтын байгууллагад 1124, албан хэрэгцээнд 380 лавлагаа гаргасан байна. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 42 лавлагаа, мэдээлэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 147 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар олгож, хууль хяналтын байгууллагад 350 албан бичгээр лавлагаа, мэдээлэл тус тус олгосон.	Улсын бүртгэлтэй холбоотой үнэн зөв лавлагаа, мэдээлэл, нотлох баримтыг хуульд заасан хугацаанд олгосон байна.	Тайлант хугацаанд иргэний улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 1791ш, хууль хяналтын байгууллагад 1333ш, албан хэрэгцээнд 456ш лавлагааг олгосон байна. Мөн хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас иргэнд 6 лавлагаа, мэдээлэл, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн мэдээллийн сангаас 61 иргэн, хуулийн этгээдэд лавлагаа хуулбар олгож, хууль хяналтын байгууллагад албан бичгээр 382 ш лавлагаа, мэдээлэл тус тус олгосон.	100%
2.2.4	Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй,	-	-Санхүүгийн тайланг найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн	2020 оны жилийн эцсийн байдлаар 8 хуулийн этгээд татан буугдсан байна.	Улсын бүртгэлээс хасагдах хуулийн этгээдийг байгууллагын	Тайлант хугацаанд 3 аж ахуй нэгж татан буугдсан байна.	100%

	харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг үндэслэн байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлан хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах ажлыг зохион байгуулах		байгууллагад илгээх; -Баталгаажуулаагүй хуулийн этгээдийг Сангийн яамны саналыг хүлээн авах; -Байгууллагын цахим хуудсаар нийтэд зарлах; -Хуульд заасан хугацаанд улсын бүртгэлээс хасах;		цахим хуудсаар нийтэд зарласан байна. Хуульд заасан хугацааны дараа хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах бүртгэл хөтөлсөн байна.		
2.2.5	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх бэлтгэл ажлыг хангах, судалгааг УБЕГазарт хүргүүлэх;	-	-Хүний нөөцийн судалгаа гаргаж, сумдын улсын бүртгэгч нарт цахимаар сургалт зохион байгуулж, бэлтгэл ажлыг хангах; -Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг суманд үзүүлж эхлэх;	Одоогоор сумдад эд хөрөнгийн бүртгэл хийгдэхгүй байгаа бөгөөд УБЕГ-ын хэмжээнд уг ажлыг эхлүүлэхээр тодорхой ажил үе шаттайгаар хийгдэж байгаа болно.	Алслагдсан сумдад эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх бэлтгэл ажлыг зохион байгуулсан байна.	2021 оны 10 дугаар сарын 07-ны өдрөөс 10 дугаар сарын 28-ны өдрийг хүртэл Улсын бүртгэлийн ерөнхий газрын “2021-2024 оны үйл ажиллагааны стратеги төлөвлөгөө”-нд тусгагдсан сумаас эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд сумдын улсын бүртгэгч нарт эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлийн хууль эрх зүйн мэдлэг олгох анхан шатны сургалтанд Алтай, Тонхил, Баян-Уул, Чандмань, Халиун, Тайшир, Эрдэнэ сумдын эрх зүйч мэргэжилтэй 7 албан хаагч нар тус тус хамрагдаж шалгалтаа амжилттай өглөө.	100%
2.2.6	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгчийн хариуцлагын даатгалын гэрээний хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах	-	-Гэрээний хэрэгжилтийн хувь;	“ХААН даатгал” ХХК-тай хамтарч бүртгэгч нарын хариуцлагын даатгал хийгдэж эхэлсэн. Одоогоор тус хэлтсээс даатгалд хамрагдсан албан хаагч байхгүй	Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарыг хариуцлагын даатгалд хамруулж, гэрээний хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	Хариуцлагын даатгалд хамрагдах эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэгч нарын судалгааг ЭХЭУБГазарт хүргүүлэн, хариуцлагын даатгалын танилцуулга сургалтанд Эд хөрөнгийн эрхийн бүртгэгч нар хамрагдсан.	

				байна.			
	...						
Зорилт 3. Улсын бүртгэл болон улсын бүртгэлийн хууль тогтоомжийн биелэлтэд тавих хяналтыг сайжруулна.							
2.3.1	Хяналт шалгалтын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангах	-	Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	2020 онд төлөвлөгөөт 19, гэнэтийн болон төлөвлөгөөт бус 4 хяналт шалгалт хийж, 304 дүгнэлт гаргасан.	Төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн хангаж, шаардлагатай арга хэмжээг тухай бүр авч ажилласан байна.	<p>Хяналт шалгалтын ажлын 11 заалт бүхий төлөвлөгөөг гаргаж, хэлтсийн даргаар батлуулан хэрэгжүүлж ажиллаж байна. Төлөвлөгөөний дагуу иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээд, архивын лавлагаа олгосон бүртгэлд өдөр тутмын болон түүвэрчилсэн, төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг хийсэн. Төлөвлөгөөт шалгалт 14, төлөвлөгөөт бус шалгалт 5, өргөдөл санал гомдлын мөрөөр 155 удаа шалгалт хийж шалгалтын дүнг илтгэх хуудсын хамт Хэлтсийн даргад танилцуулж, Хяналт шалгалтын газраас ирүүлсэн чиглэлийн дагуу хийсэн шалгалтын дүнг тухай бүр нь хүргүүлж ажилласан.</p> <p>Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, улсын бүртгэлийн архивын лавлагаа олгосон нийт 2063 бүртгэлд хяналт тавьж, 325 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа.</p> <p>Иргэний улсын бүртгэлийн 1689 бүртгэлд хяналт тавьж, хяналт шалгалтаар илэрсэн 163 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа. Төрсний, гэрлэсний, гэрлэлт цуцалсны, үрчилсний, овог, эцгийн нэр, нэр өөрчилсний, эцэг тогтоосны, нас барсны биеийн давхцахгүй өгөгдлийн, регистрийн дугаарын нийт 842 бүртгэл, иргэний үнэмлэхийн 486, шилжилт хөдөлгөөний 361 бүртгэлийг шалгасан. Улсын бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2021 оны 03 дугаар сарын 02-ны өдөр баталсан удирдамж, Хяналт шалгалтын газрын даргын 8/1364 дугаар албан бичгээр ирүүлсэн үүрэг, чиглэлийн дагуу иргэний шилжин суурьших хөдөлгөөний 2021 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2021 оны 04 дүгээр сарын 09-ний өдрүүдийн нийт 361 бүртгэлд 5 удаа шалгалт хийж, эх нотлох баримтыг цахимаар татан авч шалгахад бүртгэлийн нотлох баримтын бүрдэл шаардлага хангахгүй, үйлчилгээний хураамжийг илүү төлүүлсэн зэрэг 9 зөрчлийг илрүүлж, холбогдох сумын бүртгэгчид чиглэл өгч нөхөж бүрдүүлүүлэн, биелэлтийг шалгаж,</p>	100%

					<p>зөрчлийг арилгаж ажилласан.</p> <p>Сонгогч шилжилт хөдөлгөөнд бүртгүүлсэн нийт 772 иргэний нотлох баримтуудын бүрдүүлбэр болон өөрчлөлтийн лавлагааг нэг бүрчлэн хянаж шалган, хянасан тухай тэмдэглэж ажилласан..</p> <p>Сонгогч шилжилтээр бүртгүүлсэн 2 сонгогчийн шилжиж очсон хэсгийн дугаарыг буруу бүртгэсэн бүртгэлийг залруулсан 2 дүгнэлт гаргаж зөрчлийг арилгаж шийдвэрлэсэн.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн 194 бүртгэлд хяналт тавьж, 144 бүртгэлийн зөрчлийг арилгах шийдвэр гаргаж ажиллалаа.</p> <p>Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн архивын цахимжилтын явцад дутуу цахимжуулсан 119 бүртгэл, мөн бүртгэл хийх явцад барьцааны гэрээний үйлчилгээг бүртгэхдээ улсын бүртгэлийн дугаарыг буруу бүртгэсэн, өмчлөгчийн нэр, хаягийг буруу бүртгэсэн, үйлчилгээний нэршлийг буруу бүртгэсэн 11 бүртгэл, улсын бүртгэлийн гэрчилгээг үрэгдүүлсэн 14 гэрчилгээг хүчингүйд тооцсон хяналтын байцаагчийн дүгнэлт гаргаж шийдвэрлэсэн.</p> <p>Хуулийн этгээдийн бүртгэлийн 90 бүртгэлд хяналт тавьж, 12 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажилласан. Бүртгэлийн хувийн хэргийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн цахим мэдээллийн сантай тулган шалгахад хуулийн этгээдийн эрх шилжүүлсэн өөрчлөлт мэдээллийн санд ороогүй 4, хувийн хэргийн дугаарлалт буруу 4, үүсгэн байгуулагч болон хувьцаа эзэмшигч гишүүний мэдээллийг оруулаагүй орхигдуулсан 4 зөрчил илэрснийг арилгаж шийдвэрлэлээ. Архивын лавлагаа олгосон 95 бүртгэлд хяналт тавьсан.Алтай, Баян-Уул, Бугат, Дарив, Дэлгэр, Тонхил, Төгрөг, Хөхморьт, Цогт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ, Гуулин сумдын иргэний улсын бүртгэлийн үйл ажиллагаанд төлөвлөгөөт шалгалтыг хийж, 845 бүртгэлийн нотлох баримтыг тулган шалгаж, 101 зөрчлийг шалгалтын явцад арилгуулж шийдвэрлэсэн.</p>	
--	--	--	--	--	--	--

					Иргэдээс ирүүлсэн 23 өргөдөл, материалыг хүлээн авч, 16 өргөдлийг хуулийн хугацаанд шийдвэрлэсэн, 7 өргөдлийн хугацаа болоогүй, шийдвэрлэх шатандаа байна. Улсын бүртгэлийн зөрчил арилгах, засвар өөрчлөлт оруулах, бүртгэл хүчингүй болгох, регистрийн дугаар өөрчлөх, цахим санд бүртгэл хийх, бүртгэл сэргээн тогтоосон 113 дүгнэлт гаргаж, дүгнэлтээр 206 бүртгэлийн зөрчлийг арилган, 486 иргэний үнэмлэхийн бүртгэлийг хүчингүй болгосон. Иргэний улсын бүртгэлийн чиглэлээр 67 , хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 12 , эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн чиглэлээр 34 дүгнэлт гаргаж, Хяналт шалгалтын газраар хянуулан, биелэлтийг хангуулж ажилласан. Бүртгэл хийх явцад зөрчил гаргасан 43 бүртгэлд холбогдох бүртгэгчээс тайлбар авч, зөрчлийг арилгасан. Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч, прокурорын байгууллагын гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд тухай бүрд нь бүртгүүлэн, материалыг аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорт 5 хоног тутамд хүргүүлэн хянуулж ажиллаж байна. Тайлангийн хугацаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 206 хүнд нийт 4.120.000 төгрөгийн торгох шийтгэл ноогдуулсан.		
2.3.2	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн зөрчлийг арилгах	-	-Зөрчилтэй иргэдийн тоо; -Зөрчлийг арилгасан тоо;	2020 онд мэдээлийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 664 иргэний зөрчлийг УБЕГ-ын ИУБГ-т албан бичиг хүргүүлж арилгуулсан.	Мэдээллийн санд зөрчилтэй бүртгэгдсэн иргэдийн илэрсэн зөрчлийг 100% арилгасан байна.	2021 онд мэдээлийн санд зөрчилтэй бүртгэгдсэн 664 иргэний зөрчлийг УБЕГ-ын ИУБГ-т албан бичиг хүргүүлж арилгуулсан.	100%
2.3.3	Улсын бүртгэлийн үйл ажиллагааны явцад гарах зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах	-	Улсын бүртгэл хөтлөх үйл ажиллагаанд гарах зөрчлийг бууруулсан тоо;	2020 онд нийт 8120 бүртгэлд хяналт шалгалт хийж, 664 зөрчил илрүүлж арилгасан.	Улсын бүртгэлийн үйлчилгээ иргэн, хуулийн этгээдэд тэгш, хүртээмжтэй, чирэгдэлгүй	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн бүртгэл, улсын бүртгэлийн архивын лавлагаа олгосон нийт 2063 бүртгэлд хяналт тавьж, 325 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа	100%

					хүрсэн байна.		
2.3.4	Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх хуульд заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх	-	Шалган шийдвэрлэсэн зөрчлийн тоо;	2020 онд Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн нийт 616 иргэн, хуулийн этгээдийн зөрчлийг хялбаршуулсан журмаар хянан шийдвэрлэж, торгох шийтгэл оногдуулан 14,455,000 төгрөгийн торгууль ногдуулсан байна.	Улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн тоо буурсан байна.	Зөрчлийн талаарх гомдол мэдээллийг хүлээн авч, прокурорын байгууллагын гомдол мэдээллийн нэгдсэн бүртгэлд тухай бүрд нь бүртгүүлэн, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааг эрхлэн явуулж, материалыг аймгийн Прокурорын газрын хяналтын прокурорт 5 хоног тутамд хүргүүлэн хянуулж ажиллаж байна. Тайлант хугацаанд улсын бүртгэлийн хууль тогтоомж зөрчсөн 206 иргэнд нийт 4.120.000 төгрөгийн торгох шийтгэл ноогдуулсан.	100%
2.3.5	Аймгийн хэмжээнд иргэний байнга оршин суугаа газрын хаягийн бүртгэлийн зөрчил арилгах ажлыг зохион байгуулах	-	Арилгасан зөрчлийн тоо;	-	Иргэний оршин суугаа газрын хаягийн зөрчлийг арилгасан байна.	Иргэний шилжилтхөдөлгөөний 361 бүртгэлд хяналт тавьж, хяналт шалгалтаар илэрсэн 9 бүртгэлийн зөрчлийг арилгаж ажиллалаа.	100%
...	...						
Зорилт 4. Иргэний, хуулийн этгээдийн, эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлтэй холбоотой архивын эх нотлох баримт бичгээр архивын сан хөмрөг бүрдүүлж, баяжилт хийж, түүний хадгалалт хамгаалалтыг сайжруулна.							
2.4.1	Архивын байрны хадгалалт, хамгаалалт, хадгаламжийн сангийн нөхцөл байдлыг сайжруулах	-	Архивын стандартын хэрэгжилтийн хувь;	2020 онд Архивын стандартын хэрэгжилтийг 100 %ханган ажилласан.	Архивын стандартын хэрэгжилтийг бүрэн хангаж ажилласан байна.	Тайлант хугацаанд архивын стандартын хэрэгжилтийг хангах зорилгоор архивын нягтруулсан шүүгээ худалдан авах зардал 7.5 сая төгрөгийг Аймгийн Засаг даргаар Ийдвэрлүүлж Лүндээочир ХХК-иас архивын 6 ш нягтаршуулсан шүүгээ захиалан авч архивт байршууллаа.	100%
2.4.2	Иргэн, эд хөрөнгө, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн баримтын архивын тооллого хийж, баримтыг данс бүртгэлжүүлэх	-	-Тоолсон иргэний баримтын тоо; -Тоолсон хуулийн этгээдийн хувийн хэргийн тоо; -Тоолсон эд хөрөнгийн хувийн тоо;	2020 оны жилийн эцэст иргэний 71923, хуулийн этгээд 1256, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн 9766 хувийн хэрэг архивт хадгалагдаж байна.	Хэлтсийн иргэний баримтын архивыг100% тоолсон байна.	Улсын бүртгэлийн хэлтсийн даргын 2020.01.08 өдрийн А/01 тоот тушаалын дагуу томилогдсон ажлын хэсэг 2020 оы 01 сарын 08 ны өдрөөс эхлэн бүртгэлийн архивын баримтанд тооллого хийж 2021 оны 12 сарын 03 ны өдөр тооллогыг хийж дуусгалаа. Иргэний бүртгэлийн архив: “ Хувийн хэргийн санд” 184645 ширхэг хаатр маягт бүхий 61097 хувийн хэрэг, “Нас баралтын санд” 44188 ширхэг хаатр маягт бүхий 1104 хувийн хэрэг. Үндсэн мэдээллийн санд бүртгэлгүй 1648	100%

					хаатр маягт, мэдээлийн санд тодорхойгүй төлөвтэй 3283 хаатр маягт, регистрийн дугаар хүчингүй 792 хаатр маягт нийт 234.556 ширхэг ХААТР маягт бүхий 77867 хувийн хэрэг хадгалагдаж байна. ИГБББ санд 70жил хадгалагдах 62320 хуудас бүхий 304 х/н, 30жил хадгалагдах 132250 хуудас бүхий 529 х/н , түр хадгалагдах 266 х/н нийт 1099 хадгаламжийн нэгж бүртгэлийн дэвтэр, бүртгэл хийхэд бүрдүүлсэн анхан шатны баримт хадгалагдаж байна. Эд хөрөнгийн бүртгэлийн архивт: Газар өмчлөх эрхийн бүртгэлийн Г дугаартай 4694 хувийн хэрэг. Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгийн Ү дугаартай 5100 хувийн хэрэг нийт 9794 хувийн хэрэг, бүртгэлийн дэвтэр 203 хадгаламжийн нэгж хадгалагдаж байна. Хуулийн этгээдийн бүртгэлийн архивт Нийт 1327 хувийн хэрэг хадгалагдаж байна		
2.4.3	Байгууллагын ББНШАЗК-ын үйл ажиллагаанд хяналт тавих, хэлтсийн 2020 онд хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг боловсруулж, батлуулах, хөтлөгдөж дууссан баримт бичгийг устгах ажлын зохион байгуулах	-	-Жагсаалтыг эцэслэн батлуулсан эсэх; -Устгасан баримт бичгийн тоо;	Устгах жагсаалтыг УБЕГ-аар батлуулж нийт 23 хадгаламжийн нэгж бүхий 4114 хуудас баримт, 1997 ширхэг ИУБ маягтыг тус тус устгасан.	Жагсаалтыг үйл ажиллагаандаа мөрдсөн байна.	Устгах жагсаалтыг УБЕГ-аар батлуулж нийт 42 хадгаламжийн нэгж бүхий 4711 хуудас баримт, 6696 ширхэг ИУБ маягтыг тус тус устгасан. 2021 онд устгах бичгийн түүвэр жагсаалтыг үйлдэн 2021.09.13-ны өдөр Улсын бүртгэлийн нэгдсэн архивт хүргүүлсэн.	100%
ГУРАВДУГААР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН ТУСГАЙ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ							
	Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах талаар УБЕГ-аас гаргасан нарийвчилсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллах, дэд	-	-Нарийвчилсан төлөвлөгөөний биелэлтийн хувь; -Дэд төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь;	-	Сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө болон дэд төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлсэн байна.	Монгол улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийг хэрэгжүүлэх нарийвчилсан төлөвлөгөө болон дэд төлөвлөгөөг 100 хувь хэрэгжүүлэн ажиллав.	100%

	төлөвлөгөө батлах						
	Хууль тогтоомжийн дагуу холбогдох этгээдэд улсын бүртгэлийн мэдээ тайлан, мэдээлэл хүргүүлэх	-	-Хууль тогтоомжийн дагуу мэдээ, тайланг үнэн, зөв гаргасан байх; -Мэдээ, тайланг хугацааны хувьд хоцрогдолгүй хүргүүлэх;	Хуулиар тогтоосон шаардлага хангасан этгээдийг мэдээ, мэдээллээр бүрэн хангаж ажилласан.	Холбогдох мэдээ, мэдээллээр хангаж ажилласан байна.	Тайлант хугацаанд Прокурорын газарт сар бүрийн өргөдөл гомдол болон зөрчлийн хэрэг нээсэн тухай мэдээг хүргүүлэн ажиллаж байна.Аймгийн Төрийн аудитын газарт тус аймагт бүртгэгдсэн үл хөдлөх хөрөнгийн үнийн талаархи судалгааг хавсралтаар гаргаж хүргүүлэв.	100%
	...						

ДӨРӨВДҮГЭЭР ЗОРИЛГО: ХУУЛИАР ОЛГОСОН НИЙТЛЭГ ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ

Зорилт 5. Улсын бүртгэлийн байгууллагын удирдлагын менежмент, хүний нөөцийн төлөвлөлтийг сайжруулж, мэргэжлийн боловсон хүчний чадавхыг дээшлүүлнэ.

4.5.1	Хэлтсийн даргын Аймгийн Засаг дарга болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах гүйцэтгэлийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, батлуулах, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулах	-	-Гүйцэтгэлийн төлөвлөгөөг Аймгийн Засаг дарга болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргаар хянуулсан эсэх; -Гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд холбогдох газруудад хүргүүлсэн эсэх;	2020 онд гүйцэтгэлийн төлөвлөгөө 88,95 хувьтай хэрэгжсэн.	Гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	Аймгийн Засаг дарга болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргатай байгуулах 2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 2021 оны 03 сарын 03-ний өдөр батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	100%
4.5.2	"Хэлтсийн албан хаагчдын сургалтын төлөвлөгөө 2021"-ыг боловсруулж, хэрэгжилтийг ханган ажиллах	-	-Сургалтын төлөвлөгөө батлагдсан эсэх; -Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь; 85%	2020 онд 14 заалт бүхий сургалтын төлөвлөгөө боловсруулж батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажилласан.	Төлөвлөгөөний дагуу сургалтууд зохион байгуулагдаж, хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	-2021 оны 3 дугаар улирлын байдлаар 18 заалт бүхий сургалтын төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тус хэлтсийн албан хаагчид нийт-20 сургалтанд хамрагдсан Үүнд: Хэлтсийн дарга-1, Иргэний бүртгэлийн чиглэлээр-6, Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр-7, бүртгэлийн хяналтын чиглэлээр-4, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн чиглэлээр-3 сургалтанд холбогдох албан	100%

						тушаалтнууд тус тус хамрагдлаа.	
4.5.3	Улсын бүртгэлийн байгууллагын хүний нөөц, сургалтын нэгдсэн системээр зохион байгуулагдсан сургалт, заавартай холбогдох албан хаагчдыг бүрэн хамруулах ажлыг зохион байгуулах	-	-Сургалтад хамрагдсан албан хаагчийн тоо; -Заавартай танилцсан албан хаагчийн тоо;	Нийт сургалтаар давхардсан тоогоор 459 албан хаагч хамрагдсан байна.	Албан хаагчдыг бүрэн хамруулсан байна.	ЗГХЭГ-аас зохион байгуулсан төрийн албан хаагчийг чадавхжуулахад чиглэсэн “Үр дүнд суурилсан төлөвлөлт, хяналт, шинжилгээ, үнэлгээ” сэдэвт цахим сургалтанд хэлтсийн төрийн захиргааны 29 албан хаагч хамрагдаж төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах аргачлалд суралцаж сертификат авлаа. Орон нутгаас цахимаар болон танхимаар зохион байгуулсан 8 сургалтанд 19 албан хаагч тус тус хамрагдлаа	100%
Зорилт 6. Улсын бүртгэлийн үйл ажиллагааны эрх зүйн орчныг боловсронгуй болгож, улсын бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлнэ.							
	Улсын бүртгэлийн хэлтсийн байртай болох асуудлаар холбогдох арга хэмжээг авах	-	-Авч хэрэгжүүлсэн арга хэмжээ;	-	Төлөвлөгөөт ажил бүрэн хэрэгжсэн байна.	2021 оны 05 дугаар сарын 21, 22-ний өдрүүдэд Засгийн газрын гишүүн, Хууль зүйн сайд Х.Нямбаатар, Улсын бүртгэлийн ерөнхий газрын дарга Д.Дэлгэрсайхан нар тус аймагт ажилласан бөгөөд энэ үеэр Улсын бүртгэлийн хэлтсийн байрны асуудлыг засвар хийх төсвийн хамт шийдвэрлэсэн..	100%
4.6.1	Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх, хяналт тавих	-	-Ирүүлсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн хувь 82,35% -Мэдээ тайланг үнэн зөв гаргасан байдал 100%	2021 онд тус хэлтэст нийт 34 өргөдөл гомдол ирснийг шийдвэрлэж хариуг өгсөн. Хугацаа хоцорсон өргөдөл, гомдол байхгүй.	Өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэж, тайланг УБЕГ, аймгийн ЗДТГ-т хугацаанд нь хүргүүлсэн байна.	Тайлант хугацаанд хэлтэст нийт 44 өргөдөл, хүсэлт ирснээс 36 өргөдөл хүсэлтийг хуулийн хугацаанд шийдвэрлэж хариу хүргүүлэв. 8 өргөдлийг нь шийдвэрлэх шатандаа ажиллагаа хийгдэж байна.	100%
4.6.3	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт, баримт бичгийн эргэлтэд хяналт тавих	-	-Баримт бичгийн эргэлтийн тоо; -Хугацаатай хариутай албан бичгийн шийдвэрлэлтийн хувь;	2020 оны жилийн эцсийн байдлаар тус хэлтэст нийт 651 бичиг ирсэн, үүнээс хариутай албан бичиг 455 байсан. Хариутай албан бичгийг шийдвэрлэлтийн байдал 93,2 хувьтай.	Хэлтсийн албан хэрэг хөтлөлт стандартын дагуу явагдсан байна.	Тайлант хугацаанд тус хэлтсээс нийт 968 албан тоотыг явуулснаас хууль хяналтын байгууллагад 351 Аймгийн ЗДТГ, ИТХ-д 28 , УБЕГ-т 405 , бусад албан байгууллагад 184 албан бичгийг хүргүүлсэн байна. Мөн 311 бичиг ирсэнээс хууль хяналтын байгууллагаас 18 , Аймгийн ЗДТГ, ИТХ-аас 60 , УБЕГ-аас 178 , бусад байгууллагаас 55 бичиг ирсэн байна. Мөн хэлтэст нийт 433 хариутай бичиг ирсэнээс Хууль, хяналтын байгууллагаас 328 , аймгийн ЗДТГ, ИТХ-аас 38 , УБЕГ-аас 43 , бусад байгууллагаас 24 албан бичиг ирсэнийг холбогдох албан	96%

					хаагчид даргын цохолтоор хүргүүлж 100 хувь шийдвэрлэсэн байна. Хэлтэст нийт 44 өргөдөл ирсэнээс 36 өргөдлийг хуулийн хугацаанд нь бүрэн шийдвэрлэж 8 өргөдөл шийдвэрлэх шатандаа явж байгаа талаар батлагдсан маягт, хүснэгтийн дагуу нэгтгэж тайлан мэдээг УБЕГ болон аймгийн ЗДТГ-т тус тус хүргүүлж ажилласан. Үүнд: Эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 2 , Бүртгэлийн хяналтын үндсэн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар 32 , Хуулийн этгээдийн талаар 1, санхүүгийн үйл ажиллагаатай холбоотой 9 өргөдөл тус тус ирсэнийг холбогдох албан хаагчдад нь даргын цохолтоор хүргүүлж ажилласан байна.		
4.6.4	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих	-	-Үйлчилгээний стандартын хэрэгжилтийн хувь; -Ёс зүйн арга хэмжээ авагдсан албан хаагчдын тоо;	-	Үйл ажиллагаандаа дүрэм, журмыг мөрдөж, стандартын зөрчил гараагүй байна.	Улсын бүртгэлийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам, үйлчилгээний стандарт, төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Тайлант хугацаанд иргэдээс албан хаагчдын харьцаа хандлага, үйл ажиллагаатай холбоотой ямар нэгэн гомдол, санал ирээгүй.	100%
4.6.5	Албан хаагчдыг эрүүл мэндийн үзлэг, оношилгоо, шинжилгээнд сайн дурын үндсэн дээр хамруулах ажлыг зохион байгуулах	-	Албан хаагчдыг сайн дурын үндсэн дээр эрүүл мэндийн үзлэгт хамруулсан эсэх;	2020 онд нийт 33 албан хаагчийн эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт сайн дурын үндсэн дээр хамруулсан.	Хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	-2021 оны 1 дүгээр сард хэлтсийн аймгийн төвд ажиллаж байгаа 18 албан хаагчийг эрүүл мэндийн урьдчилсан үзлэгт хамруулав. -2021 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр хэлтсийн 18 албан хаагчийг Ковид-19 өвчний эсрэг 1 дүгээр тунд, 4 дүгээр сарын 29-ны өдөр вакцины 2 дахь тунд хамрууллаа. -Сумдын улсын бүртгэгчдийг 2021 оны 04 сарын 29-ны өдрөөс 2021 оны 05 сарын 31-ны өдрийн хооронд вакцины 1,2 дугаар тунд бүрэн хамруулсан. -2021 оны 09.10 саруудад Вакцины 3 дугаар тунд хэлтсийн 20 албан хаагчийг хамрууллаа.	100%
4.6.6	Даргын зөвлөлийн болон бүх албан хаагчдын хурлын тэмдэглэл хөтөлж, гаргасан	-	-Хөтөлсөн хурлын тэмдэглэлийн тоо; -Үүрэг даалгаврын тоо; -Үүрэг даалгаврын	2020 онд 5 удаагийн даргын зөвлөлийн шуурхай хуралдаан зохион байгуулж, албажуулс	Тэмдэглэлийг тухай бүр нь албажуулан хурлаас өгөгдсөн үүрэг,	Тайлант хугацаанд даргын зөвлөлийн шуурхай хуралдааныг 11 удаа, хамт олны хурлыг 17 удаа танхимаар, 9 удаа онлайнаар тус тус зохион байгуулж, албажуулсан ба нэгжүүдэд 19 үүрэг даалгавар өгөгдсөний	100%

	шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавих		хэрэгжилтийн хувь;	ан ба нэгжүүдэд 13 үүрэг даалгавар өгөгдсөний хэрэгжилт 100 хувийн биелэлттэй.	даалгаврууд бүрэн хэрэгжсэн байна.	хэрэгжилт 100 хувийн биелэлттэй байна.	
4.6.7	Улсын бүртгэлийн ерөнхий газраас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой ирүүлсэн даргын тушаал шийдвэрийг хяналтад авч бүртгэл хөтлөх	-	Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой даргын тушаал, шийдвэрийн тоо, хяналтад авсан эсэх;	2020 оны жилийн эцэст тус хэлтэст УБЕГ-ын даргын 17 тушаал, 13 үүрэг даалгавар, чиглэл ирснийг бүрэн ажилласан.	Тушаал шийдвэрийн бүртгэлийг сар, өдрийн дарааллаар нарийн хөтөлсөн байна. Хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	Тайлант хугацаанд тус хэлтэст УБЕГ-ын даргын Тушаал-19, үүрэг даалгавар-2, чиглэл-13, зөвлөмж-22, судалгаа ирүүлэх тухай албан бичиг зэрэг ирснийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан.	100%
4.6.8	Байгууллагын нууцын ажлыг Төрийн болон албаны нууцын тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд зохион байгуулах	-	Холбогдох хууль тогтоомжийн хүрээнд ажил зохион байгуулагдаж, шаардлагатай арга хэмжээ авч ажилласан эсэх;	2020 онд Төрийн болон албаны нууцтай холбоотой 4 бичиг ирсэнээс 2 хариутай албан бичиг ирсэний хариуг хугацаанд нь явуулсан.	Хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.	Тайлант хугацаанд Төрийн болон албаны нууцтай холбоотой 6 бичиг ирсэнээс 2 хариутай албан бичиг ирсэний хариуг хугацаанд нь явуулсан.	100%
4.6.9	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээлэл бэлтгэх, олон нийтэд хүргэх	-	Сар бүр иргэн, хуулийн этгээдэд үзүүлсэн үйлчилгээний талаарх инфографик мэдээллийг бэлтгэн брошур хэлбэрээр байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулсан тоо;	2020 онд фэйсбүүк хуудас болон цахим хуудсанд сар бүрийн мэдээ, статистик тоон мэдээг хугацаанд нь байршуулсан.	Сар бүр мэдээлэл байршуулсан байна.	Байгууллагаас сар бүр үзүүлсэн үйлчилгээний талаар инфографик мэдээллийг тухай бүр нь бэлтгэж байгууллагын цахим хуудас болон фэйсбүүк хаягаар дамжуулан иргэдэд хүргэж ажиллаж байна.	100%
4.6.10	Хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох	-	-Хэрэг маргаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцсон тоо; -Шийдвэрийн мэдээлэл; -Хэрэг маргааны судалгаа эрх зүйн хэлтэст хүргүүлсэн	2020 онд хуулийн этгээдийн чиглэлээр "Алтайн сүрлэг нуруу" ХХК-ний нэхэмжлэлтэй хэрэг маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр	Хууль, шүүхийн байгууллагаар хянан шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргаанд байгууллагын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр	Тайлант хугацаанд хууль, шүүхийн байгууллагаар шийдвэрлэгдэж байгаа хэрэг маргааны асуудал байхгүй.	100%

			байдал;	хяналтын улсын байцаагч, хуулийн этгээдийн улсын бүртгэгч нар ажилласан, эд хөрөнгийн эрхийн бүртгэлийн чиглэлээр иргэн Эрдэнэбилэгийн нэхэмжлэлтэй Y0518000371 дугаартай бүртгэлийг хүчингүй болгох хэрэг маргаанд хариуцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Хяналтын улсын байцаагч ажилласан. Уг 2 хэрэг маргаан Улсын бүртгэлийн талд шийдвэрлэгдсэн. Хэрэг маргааны судалгаа эрх зүйн хэлтэст 2 удаа хүргүүлсэн.	оролцож, байгууллагын эрх ашгийг бүрэн хамгаалсан байна.		
4.6.11	Байгууллагын үйл ажиллагааг цахим, фэйсбүүк хуудсаар болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах, телевиз радиогийн нэвтрүүлэгт оролцох	-	-Байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээ, мэдээллийг цахим хуудаст байршуулсан тоо; -Олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилсан тоо;	2020 онд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой мэдээ мэдээллийг цахим болон фэйсбүүк хуудсанд тухай бүр нь байршуулсан. Орон нутгийн телевиз, сонинд 2 удаа мэдээлэл хийсэн.	Байгууллагын үндсэн үйл ажиллагаа болон цаг үеийн чанартай хийж хэрэгжүүлж буй ажлын талаар иргэд, олон нийт мэдээ мэдээлэлтэй болсон байна.	Тайлант хугацаанд хэлтсийн үйл ажиллагаатай холбоотой 168 мэдээ мэдээллийг цахим болон фэйсбүүк хуудсанд тухай бүр нь байршуулсан байна. Орон нутгийн телевиз, сонинд 3 удаа мэдээлэл хийсэн.	100%
4.6.12	Улсын бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх “Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион	-	“Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулсан тоо;	2020 онд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 6 удаа зохион байгуулсан.	Нээлттэй хаалганы өдөрлөгийг 5-с доошгүй удаа	Тайлант хугацаанд “Нээлттэй хаалганы өдөрлөг”-ийг 2 удаа зохион байгуулсан.	

	байгуулах				зохион байгуулсан байна.		
4.6.13	Иргэдийн санал хүсэлтийг сонсох 90484103 утасны үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах	-	-Утсаар лавлагаа мэдээлэл авсан тоо;	Хэлтсийн лавлах утсанд 43 иргэн утсаар холбогдсон, тухай бүр нь мэдээлэл өгч ажилласан.	Улсын бүртгэлийн чиглэлээр иргэдэд үнэн зөв, бодитой мэдээлэл хүргэсэн байна.	Хэлтсийн лавлах утсанд 425 иргэн утсаар холбогдсон бөгөөд тухай бүр нь мэдээлэл өгч ажилласан.	100%

Зорилт 7. Гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, улсын бүртгэлийн үйл ажиллагааны талаар гадаад улс, олон улсын бүртгэлийн байгууллагатай Монгол Улсын хууль тогтоомж, олон улсын гэрээний дагуу хамтран ажиллана.

4.7.1	Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авах		Санал тавьж шийдвэрлүүлсэн эсэх;	2020 онд Аймгийн ИТХ, Засаг дарга болон төрийн байгууллагуудтай нягт хамтран ажиллаж дэмжлэг авсан.	Тулгамдсан асуудлаа шийдвэрлүүлсэн байна.	-Хэлтсийн байрны асуудлыг Аймгийн Засаг даргаар шийдвэрлүүллээ. - Аймгийн Засаг даргаас тус хэлтэст архивын шүүгээ худалдан авахад зориулж 7.5 сая төгрөгний санхүүгийн дэмжлэг үзүүлж Лүндээ-очир ХХК-аас архивын шүүгээ 6 ш захиалан авч архивт байршууллаа.	100%
	...						

Зорилт 8. Санхүү, төсвийн удирдлага болон төсвийн гүйцэтгэлийн хяналтыг хэрэгжүүлнэ.

4.8.1	Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулах, тайлагнах, байршуулах	Батлагдсан төсөв	-Төсвийн өр, авлага үүсгэсэн эсэх; -Төрийн аудитын шалгалтаар зөрчилгүй ажилласан эсэх;	2020 онд бүртгэлийн үйлчилгээний орлогоор улсын төсөвт 90 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөнөөс 90,5 сая төгрөг төвлөрүүлж биелэлт 100,5 хувьтай байна. Мөн төсвийн өр авлагагүй ажилласан. Аймгийн Төрийн аудитын газар 2019 оны санхүүгийн тайланд аудитын шалгалт хийж "ЗӨРЧИЛГҮЙ" санал дүгнэлтийг өгсөн. Зөвлөмж акт, албан	Байгууллагын төсвийн хөрөнгийг зүй зохистой, хэмнэлттэй зарцуулж, тайлан мэдээг холбогдох байгууллагуудад хугацаанд нь хүргүүлж, аудитын зөрчилгүй дүгнэлт авсан байна.	2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн байдлаар 464,343,600.00 төгрөгний санхүүжилт авч 456,318,941.00 төгрөгийг зориулалтын дагуу зарцуулж өр, авлагагүй ажиллаж байна. энэонд бүртгэлийн үйлчилгээний орлогоор улсын төсөвт 90,0 сая төгрөг төвлөрүүлэх төлөвлөгөөнөөс 101,8 сая төгрөг төвлөрүүлж биелэлт 113 хувьтай байна. Аймгийн Төрийн аудитын газар 2020 оны санхүүгийн тайланд аудитын шалгалт хийж "ЗӨРЧИЛГҮЙ" санал дүгнэлтийг өгсөн. Зөвлөмж акт, албан шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна.	100%
-------	---	------------------	--	--	---	---	------

				шаардлага аваагүй болно.			
4.8.2	Улсын бүртгэлийн байгууллагын байрны ашиглалт, үнэт цаас, маягт, бараа материалын хангалт, үйлчилгээг хариуцан зохион байгуулах зарцуулах, тайлагнах	-	-Төрийн өмчийн эд хөрөнгийн тооллогыг цаг тухайд хийсэн болон ашиглалтгүй хөрөнгийн асуудлыг шийдвэрлэсэн эсэх; -Үнэт цаас, маягт болон бусад бараа материал, жижиг эд хогшлын хангалтыг тасалдуулаагүй эсэх; -Байгууллагын үнэт цаас, маягт болон бусад бараа материалыг хэмнэлттэй зарцуулсан болон батлагдсан төсөв хэмнэсэн эсэх;	2020 онд хөрөнгийн тооллогыг хагас бүтэн жилт 2 удаа хийж шийдвэрлэсэн. Үнэт цаасыг хугацаанд нь татан авч хангалтыг тасалдуулаагүй ажилласан. Байгууллагын бараа материалын ашиглалтын тайланг сар бүр гаргаж бичгийн цаас, хорны хэмнэлтийг гаргаж ажилласан.	Хагас жилээр эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн өмнө байгууллагын үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллогыг хийсэн, ашиглалтгүй хөрөнгийг данснаас хасах талаар байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн шийдвэр гаргуулж, УБЕГ-ын Санхүү, аж ахуйн хэлтэст хүргүүлсэн байна.	Хэлтсийн даргын 2021 оны А/17 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2021.11.30-ны байдлаар 373,944,946.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна. Хэлтсийн албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг хүн тус бүрээр хөтөлж байна. 2021.11.30-ны байдлаар УБЕГ-аас 13,874,540.00 төгрөгийн үнэт цаас, 359,180.00 төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, 1,854,600.00 төгрөгийн бичиг хэргийн материал, 7,990,000.00 төгрөгийн аж ахуйн материал, 255,000.00 төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 28,298,000.00 төгрөгийн нэг удаагийн хамгаалах хэрэгсэл нийт 52,631,320.00 төгрөгийн бараа материалыг татан авсан. Мөн батлагдсан төсвөөс 4,828,000.00 төгрөгийн бичиг хэргийн материалыг худалдан авч тайланг сар бүр гарган ажиллаж байна.	100%
4.8.3	Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллах	-	-Байршуулсан шилэн дансны мэдээллийн тоо; -Хугацаандаа байршуулсан эсэх;	2020 оны 12 сарын 25-ны байдлаар шилэн дансны цахим сайтад 137 мэдээлэл оруулахаас 133 мэдээлэл хугацаа хоцролгүй, үнэн зөв байршуулсан. Хугацаа хоцорсон мэдээлэл 4 байна.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт бүрэн хангагдсан байна.	2021 оны 12 сарын 03-ны байдлаар шилэн дансны цахим сайтад 133 мэдээлэлийг хугацаа хоцролгүй, үнэн зөв байршуулсан.	100%
4.8.4	Байгууллагын өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааг	-	-Төлөвлөгөө гарган хэрэгжилтийг хангаж ажиллах; -Хүчингүй болсон	Байгууллагын эд хөрөнгийн тооллого, хүчингүй болгосон үнэт цаасны	Өмч хамгаалах зөвлөлийн ажил тогтмолжсон байна.	Байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн ажлын төлөвлөгөөг гарган хэлтсийн даргаар батлуулан ажиллаж байна. Улсын бүртгэгч нараас ирүүлсэн үнэт	100%

сайжруулах, тогтмолжуулах		<p>үнэт цаас, тамга тэмдгийг журмын дагуу устгах; -Төрийн болон орон нутгийн өмчийн улсын тооллогод бэлтгэх; - Байгууллагын эд хөрөнгийн тооллого хийх; -Байгууллагын эд хөрөнгийн бүртгэлийн сантай болох; -Хэрэглэгдэж байгаа бүх тоног төхөөрөмжийн ашиглалт үзүүлэлтийн судалгаа гаргах; -Тайланг 2 удаа хагас бүтэн жилээр гаргаж тайлагнах;</p>	<p>зарцуулалт, ашиглалтын хугацаа дууссан эд хөрөнгийг актлах зэргээр 3 удаа хуралдан шийдвэр гаргаж ажилласан.</p>		<p>цаасны тайланд тусгагдсан хүчингүй болсон үнэт цаасыг сар бүр хүчингүй болгосон акт үйлдэн, ашиглагдахаа байсан нийт 1,880,597.00 төгрөгний үнэт цаас, маягтыг байгууллагын өмч хамгаалах байнгын зөвлөлийн хурлаар хэлэлцэж уг шийдвэрийн дагуу хэлтсийн даргын 2021 оны А/16 тоот тушаалаар акталж, устган, данснаас хассан байна.</p> <p>Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний 2020 оны биелэлтийг гаргаж хүргүүлэн 95% /ерэн тав хувь/-тай дүгнүүлсэн. Мөн төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээг 2021.09.30-ны өдөр №2021/ГАА/21-0112 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргаар батлуулан ажиллаж байна.</p> <p>Хэлтсийн даргын 2021 оны А/17 тоот тушаалаар үндсэн хөрөнгийн жилийн эцсийн тооллогыг хийж гүйцэтгэсэн бөгөөд 2021.11.30-ны байдлаар 373,944,946.00 төгрөгийн үндсэн хөрөнгө бүртгэлтэй байна.</p> <p>Хэлтсийн албан хаагчдын хэрэглэж байгаа эд хөрөнгийн ашиглалтын бүртгэлийг хүн тус бүрээр хөтөлж байна.</p> <p>Тоног төхөөрөмжийн ашиглалтын талаарх судалгааг гаргаж УБЕГ-ын МТГазарт хүргүүлсэн.</p>	
------------------------------	--	---	---	--	---	--

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвараа сайжруулах арга хэмжээ	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Гүйцэтгэл	Хувь
1	<p>Арга хэмжээ №1. Үндэсний монгол бичгийн мэдлэгээ дээшлүүлэх:</p>	<p>Үндэсний монгол бичгийн мэдлэг дээшилсэн байна</p>	<p>Танхимаар 7 хоногт 1 удаа, онлайнаар 7 хоногт 3 удаа сургалтанд хамрагдах бие даан суралцах</p>	<p>Байгууллагын сургалтын төлөвлөгөөнд орсны дагуу үндэсний монгол бичгийн багц сургалтанд хамрагдаж танхимаар болон онлайн хэлбэрээр суралцаж, мэдлэгээ тодорхой хэмжээнд ахиулсан.</p>	100
2	<p>Арга хэмжээ №2. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжийг судлаж, сургалтад хамрагдан өөрийгөө тасралтгүй хөгжүүлэх</p>	<p>Сургалтанд бүрэн хамрагдсан байна.</p>	<p>Онлайнаар суралцах, бие даан мэдлэгээ дээшлүүлэх</p>	<p>УБЕГ-аас зохион байгуулсан сургалтуудад бүрэн хамрагдсан. ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн мэргэжлийн түвшинг үнэлэх аргачлал”-ыг судлан үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллаж байна. Мөн “Төрийн албаны шинэтгэл” сэдэвт сургалтад</p>	100

				хамрагдсан. Авлигын эсрэг үндэсний чуулганд цахимаар оролцсон.	
3	Арга хэмжээ №3 Удирдах ажилтанд зориулсан сургалтуудад хамрагдаж мэдлэгээ дээшлүүлэх	Сургалтанд бүрэн хамрагдсан байна.	Онлайнаар суралцах, бие даан мэдлэгээ ахиулах	УБЕГ-аас 09 дүгээр сарын 10-нд зохион байгуулагдсан удирдах ажилтны сургалтанд хамрагдсан. Сургалтаар өгөгдсөн чиглэл үүргийг бүрэн хэрэгжүүлж ажиллаж байна.	100
4	Арга хэмжээ №4. Гамшгийн үеийн хамтын ажиллагааны талаарх асуудлыг судлаж, мэдлэг чадвараа дээшлүүлэх	Холбогдох газрын сургалтанд хамрагдаж, мэдлэгээ дээшлүүлсэн байна	Онлайн болон танхимын сургалтанд хамрагдах	Гамшгаас хамгаалах хууль, Галын аюулгүй байдлын тухай хууль, гамшиг ослын тухай ерөнхий ойлголт сэдвээр аймгийн Онцгой байдлын газраас 2021 оны 10 сарын 02-ны өдөр зохион байгуулсан сургалтанд хамрагдаж, мэдлэг олж авсан	
5	Арга хэмжээ №5. Мэдээллийн технологи, сүлжээ, компьютерийн орчинд ажиллах мэдлэг чадвараа дээшлүүлэх	Програм хангамж болон техникийн мэдлэг дээшилсэн байна	Дадлагаар болон сургалтаар мэдлэгээ дээшлүүлэх	Тайлант хугацаанд компьютер интернэтийн орчинд ажиллах болон оффисын өргөн хэрэглээний програм болох word, excel, power point ажиллах мэдлэг ур чадвараа дээшлүүлсэн.Үүнд: бичиг хэргийн стандартад нийцүүлэн баримт бичгийн стандартыг тохируулан боловсруулж сурсан, өөрийн илтгэл тавих материалаа програм дээр өөрөө бэлдэж танилцуулж сурсан. Мэдээллийн технологийн сүлжээ, техник хэрэгслийг ашиглаж сурсан. Үүнд: интернэтийн сүлжээг свичээр холбох, сүүлийн үеийн төхөөрөмжүүд болох принтер, сканерийг ашиглаж сурсан.	100
	Арга хэмжээ №5. Хамтын манлайлал, багаар ажиллах чадвараа дээшлүүлэх.	Багаар ажиллах чадвар дээшилсэн байна.	баг хамт олноороо амжилт гаргах	Төрийн албаны шинэтгэлийн хүрээнд төрийн албан хаагчдын манлайллын асуудлыг судалж, мэдлэгээ дээшлүүлсэн. Мөн багаар ажиллах зарчмууд, хандлага харилцааны талаарх асуудлуудыг судалж хамт олондоо мэдээлэл хийсэн. Говь-Алтай аймаг нь 2021 онд "Үндэсний бичигтэн аймаг" болох томоохон зорилтыг дэвшүүлсэн . Уг арга хэмжээнд Аймгийн засаг даргын ивээл дор, Соёл урлагийг дэмжих сангийн дэмжлэгтэйгээр төрийн албан хаагч, ард иргэдийн монгол бичгийн олимпиадад 2021.11.22-оос 25-ны өдрүүдэд хэлтсээрээ хамрагдаж, "Монгол улсын Засгийн газраас баталсан "Монгол бичгийн үндэсний хөтөлбөр-III"-ыг хэрэгжүүлэх, эх хэлээ эрхэмлэн дээдэлж түгээн дэлгэрүүлэх, үндэсний бичгийн мэдлэг чадварыг ахиулах" зорилготой тус уралдаант шалгалтанд амжилттай оролцож, Сургууль цэцэрлэг, соёл боловсролын байгууллагатай энэ чацуу өрсөлдөж, төрийн байгууллагуудаас шагналт 4-р байр эзлэв.	100

Тайланг хянасан:

Төсвийн Ерөнхийлөн захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГА
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Д.ДЭЛГЭРСАЙХАН/

Тэмдэг

.....(огноо)

Тайлан гаргасан:

Төсвийн Шууд захирагч

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ХЭЛТСИЙН ДАРГА
(албан тушаал)

.....

/Г.ЧҮЛТЭМЖАМЦ/

(гарын үсэг)

Тэмдэг

.....(огноо)